



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А-17/04

Дархан



Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан
сэргийлэх ёс зүйн дүрэм батлах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.10 дахь заалт, Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.2, 10.3, 10.4, 10.5 дахь заалт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Засгийн Газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Тус албаны улсын /ахлах/ улсын байцаагч, дотоод аудиторуудын ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс "Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрэм"-ийг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг нийт бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

ДАРГА  Б.БААСАНЖАРГАЛ



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ
УЛСЫН БАЙЦААГЧ, ДОТООД АУДИТОРЫН АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Дархан-Уул аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны Улсын байцаагч, дотоод аудитораас албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоон, түүнийг хэлбэрэлтгүй дагаж мөрдөх, сахин биелүүлэх, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ дүрмийн зорилго оршино.

1.2 Монгол улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Авлигын эсрэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм", "Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар батлагдсан "Стандарт"-аар тогтоосон хэм хэмжээ, зарчим, ёс зүйн стандарт нь улсын байцаагч, дотоод аудиторын ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийн эрх зүйн үндэс мөн.

1.3 Дархан-Уул аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны хэмжээнд энэхүү дүрмийг дагаж мөрдөж, хяналт, хариуцлагын тогтоолцоог бүрдүүлэн ажиллана.

Хоёр. Хамрах хүрээ

2.1 Энэхүү дүрэм нь хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж байгаа нийт улсын байцаагч /ахлах/, дотоод аудиторуудад хамаарна.

Гурав. Нэр томъёоны тодорхойлолт

Энэхүү дүрэмд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

3.1 Санхүүгийн хяналт, аудитын албаны улсын байцаагч, дотоод аудиторын ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн хэм хэмжээ гэж улсын байцаагч, дотоод аудитор нь өргөсөн тангарагтаа үнэнч байж, хуульд заасан зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэх явцад үйл ажиллагаандаа эрхэмлэн сахих зан үйлийн нийлбэр цогцыг;

3.2 "Санхүүгийн хяналт, аудитын албаны улсын байцаагч" гэж Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.6 дугаар заалтад "Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, ахлах байцаагчийн эрхийг Санхүүгийн хяналт шалгалтын улсын ерөнхий байцаагчийн шийдвэрээр олгоно" гэж заасны дагуу улсын байцаагчийн эрх авсан этгээдийг;

3.3 “Дотоод аудитор” гэж Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.4 дүгээр заалтад “санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг, эрх зүйн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй, тухайн салбарт мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний зөвшөөрлөөр албан ёсоор зохион байгуулсан сургалтад хамрагдсан этгээдийг;

3.4 “Ашиг сонирхлын зөрчил” гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг;

3.5 “Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал” гэж тухайн нийтийн албан тушаалтан өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг.

3.6 Улсын байцаагч, дотоод аудиторын ёс зүйн зөрчил гэж холбогдох хууль тогтоомж, стандарт, энэ дүрмээр тогтоосон улсын байцаагчийн ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн хэм хэмжээг санаатай болон санамсаргүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдлийг;

Дөрөв. Ёс зүйн зарчим

4.1. Санхүүгийн хяналт, аудитын албаны улсын байцаагч, дотоод аудитор нь үйл ажиллагаанд дор дурдсан зарчмыг баримтална.

- Ёс зүйг дээдлэн-Манлайлагч байх;
- Хууль дээдлэн-Хэрэгжүүлэгч байх;
- Шударга ёсыг сахиж-Хариуцлага хүлээх
- Ил тод, хараат бус байж-Тэгш байдлыг хангах;
- Олон нийтэд үйлчилж-Хүртээмжтэй байх

Тав. Ёс зүйн эрхэмлэн дээдлэх зүйлс

5.1. Төрийн захиргааны албан хаагч нь энэ дүрмийн 4.1-д заасан зарчмын хүрээнд төрийн бодлого, байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг үзүүлэхдээ дор дурдсан зүйлсийг эрхэмлэн дээдэлнэ:

5.1.1. Ёс зүйг дээдлэн-Манлайлагч байх зарчмын хүрээнд байгууллагын үнэт зүйлс, соёл, улсын байцаагчийг ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйг дээдлэн, өөрийн мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлж, бусдыг үлгэрлэн манлайлах

5.1.2. Хууль дээдлэн-Хэрэгжүүлэгч байх зарчмын хүрээнд: төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хяналт шалгалт гүйцэтгэх болон албаны бусад чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагаанд Үндсэн хууль, бусад хуулийг ямагт дээдлэн сахиж даган мөрдөж, хуульд нийцсэн, үндэслэл нотолгоотой шийдвэр гаргаж байх;

5.1.3. Шударга ёсыг сахиж-Хариуцлага хүлээх зарчмын хүрээнд; Хүлээсэн үүрэг, өргөсөн тангарагтаа үнэнч байж, аливаа хувийн ашиг сонирхолын зөрчлөөс ангид, зөвхөн нийтийн ашиг сонирхолд захирагдан чин шудрагаар ажиллаж, хийсэн ажлын гүйцэтгэл, үр дүн, гаргасан шийдвэрийнхээ эцсийн хариуцлагыг хүлээх;

5.1.4 Ил тод, хараат бус байж-Тэгш байдлыг хангах зарчмын хүрээнд: хяналт шалгалтын болон улсын байцаагчийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод, хараат бус байж, бусад аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, иргэн бүртэй адил тэгш, алагчлалгүй харьцах;

5.1.5. Олон нийтэд үйлчилж-Хүртээмжтэй байх зарчмын хүрээнд: төрийн үйлчилгээг олон нийтэд чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэж, тэдний итгэлийг хүлээж ажиллах.

Зургаа Ёс зүйн хэм хэмжээ

Ёс зүйтэй хяналтыг хэрэгжүүлэх нь Санхүүгийн хяналт, аудитын байгууллага, улсын байцаагч, дотоод аудиторын нэр хүнд, нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэх, байгууллагын зорилт, чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэх үндсэн нөхцөлийн нэг жчраас энэхүү дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээг заавал сахин биелүүлэх нь улсын байцаагч, дотоод аудиторын үүрэг мөн.

6.1 Улсын байцаагч, дотоод аудитор нь энэхүү дүрмийн 5.1.1-д заасан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээн дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

6.1.1 Санхүүгийн хяналт аудитын байгууллагын удирдлагын зарчмыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, байгууллагын удирдах албан тушаалтнаас хуульд нийцүүлэн гаргасан шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлэх;

6.1.2 Санхүүгийн хяналт, аудитын байгууллагын нэр хүндийг цэвэр ариун байлгаж, байгууллагын хөгжил дэвшилд бодитой хувь нэмэр оруулах;

6.1.3 Өөрийн мэдлэг, ур чадвар, мэргэшил, туршлагаа байнга дээшлүүлж, ажил үүргээ мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх;

6.1.4 Хамт олны эвсэг, нөхөрсөг, бүтээлч байдлыг эрхэмлэж, зан төлөвийн муу зуршил, дутагдал гаргахгүй байх;

6.1.5 Албан ажилдаа ямагт чин сэтгэлээсээ өөриймсөг хандаж, ажлын цагийг үр бүтээлтэй, бүрэн дүүрэн ашиглах;

6.1.6 Гадуур ажиллах болон ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах болон сэтгэгцэд нөлөө үзүүлэх бодис хэрэглэхийг цээрлэх;

6.1.7 Ажлын байранд болон албан үүргээ гүйцэтгэж байхдаа албан хувцас өмсөж хэвших;

6.1.8 Албан үүргээ гүйцэтгэж байхдаа ааливаа хэлбэрээр бүдүүлэг зан авир гаргахыг тэвчих;

6.1.9 Гэр бүл, үр хүүхэддээ халамж анхааралтай байж, ёс суртахууны нийтээр зөвшөөрөгдсөн хэм хэмжээг сахин мөрдөх;

6.1.10 Хувийн ашиг, орлого олох зорилгоор ажлын байранд, хамт олондоо болон шалгуулагч этгээд, үйлчлүүлэгч нарт бараа бүтээгдэхүүн сурталчлах, худалдан борлуулах үйл ажиллагаа явуулахыг хориглох;

6.1.11 Байгууллагын өмч хөрөнгө, техник хэрэгслийг ариг гамтай, зориулалтын дагуу хэрэглэж, тэдгээрийг болон албаны мэдээллийг албан бус зорилгоор ашиглахгүй байх;

6.1.12 Мэдлэг, ур чадвар, ажилдаа хандах хандлага, шийдвэр гаргалт, үйл хөдлөл, үг яриа, харилцааны соёл, биеэ авч явах байдлаараа бусдад үлгэр дууриалал үзүүлж, манлайлж ажиллах.

6.2. Улсын байцаагч, дотоод аудитор нь энэхүү дүрмийн 5.1.2-т заасан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээнд дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

6.2.1 Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, нийтээр болон байгууллагын хэмжээнд дагаж мөрдөж байгаа эрх зүйн актыг чанд баримталж, сахин биелүүлэх;

6.2.2 Захирах, захирагдах ёсны зарчмыг баримталж, тодорхой асуудлаар өөр саналтай байсан ч удирдлагаас гаргасан хуульд нийцсэн шийдвэр, өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх;

6.2.3 Харьяа дээд шатны албан тушаалтныг төрийн бодлого боловсруулах, асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргахад нь хуульд нийцсэн, баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээлэл, судалгаа, мэргэжлийн зөвлөгөө, арга зүйгээр хангах;

6.2.4 Албан ажилд шаардлагатай мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулахыг цээрлэх;

6.2.5 Харьяалах нэгжийн даргын зөвшөөрөлгүйгээр төр, засгийн болон байгууллагын бодлого, үйл ажиллагааг нийтэд дур мэдэн мэдээлэх, өөрийн үзэл бодол, улс төрийн шалтгаанаар тайлбар, таниулга хийхийг хориглох

6.2.6 Хууль тогтоомжид заасан нууцалбал зохих шийдвэрлэгдээгүй мэдээллийг тараах, байгууллагаас явуулж буй бодлого, хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан шийдвэрийг гуйвуулан тайлбарлахыг хориглох

6.2.7 Үзэл бодлоо илэрхийлж үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх эрх чөлөөгөө эдлэхдээ өөрийн албан тушаалдаа хүндэтгэлтэй хандаж, төрийн байгууллага,

түүгээр үйлчлүүлэгчдийн хоорондын харилцаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байдал гаргахыг цээрлэх

6.2.8 Үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг эрхлэхгүй байх

6.2.9 Албан тушаалын бүрэн эрхээ аливаа улс төр, үзэл суртлаас ангид байдлаар хэрэгжүүлэх

6.2.10 Төрийн бус байгууллагад сонгогдон ажиллаж болох боловч тэрхүү сонгууль, томилолт нь албан хаагчийн хувьд албан үүргээ хэрэгжүүлэхэд саад болохгүй байх

6.2.11 Сонгуульд нэрээ дэвшүүлэх бол албан тушаалаас түр чөлөөлөгдөх хүсэлтээ гаргаж, төрийн бус байгууллагын орон тооны албан тушаалд өөрийн нэрийг дэвшүүлэх бол энэ тухайгаа байгууллагынхаа эрх бүхий албан тушаалтанд урьдчилан мэдэгдэх

6.2.12 Албан үүргээ гүйцэтгэж байхдаа төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг задруулахгүй байж, хувийн болон бусдын ашиг сонирхолын төлөө ашиглах, албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараахгүй байх

6.2.13 Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн аливаа арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох, ажил хаях, жагсаал цуглаан хийх, өлсгөлөн, суулт зарлах зэрэг улс төрийн үйл ажиллагаанд оролцохыг цээрлэх

6.3 Улсын байцаагч, дотоод аудитор нь энэхүү дүрмийн 5.1.3-д заасан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээнд дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

6.3.1 Өргөсөн тангарагтаа үнэнч байж, эх орон, ард түмнийхээ эрх ашгийг хувийн ашиг сонирголоос ямагт дээгүүр тавьж, ашиг сонирхолын зөрчил үүсгэж болзошгүй аливаа нөхцөл байдлаас татгалзах

6.3.2 Ашиг сонирхолын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл энэ талаарх тайлбараа бичгээр гаргаж, харъяалагдах нэгжийн даргад хүргүүлэх

6.3.3 Удирдлагын санал бодолд нийцэх сэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй үр дагавар, сөрөг талыг урьдчилан анхааруулж байх

6.3.4 Хууль зөрчсөн, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан болон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэлтэй эвлэршгүй байж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэх

6.3.5 Албан үүргээ гүйцэтгэсэн болон гүйцэтгээгүйн улмаас ашиг сонирхол нь хөндөгдөх, дотоод гадаадын аливаа иргэн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, тэдэнтэй үгсэн тохирох, амлалт өгөхийг цээрлэх

6.3.6 Албан тушаал, хуулиар олгосон эрх мэдлээ хувийн зорилгод ашиглах, албан үүргээ хэрэгжүүлсэнтэй холбогдуулан бусдаас бэлэг сэлт, шан харамж, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл авах, бусдын нөлөөнд автах, хууль бус бусад хангамж эдлэхийг цээрлэх;

6.3.7 Албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, албаны нэрээр түрүү барих, бусдыг дарамтлах, далайлган сүрдүүлэх, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгахыг хориглох;

6.3.8 Бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар харъяалах нэгжийн даргад, шаардлагатай тохиолдолд Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх;

6.3.9 Хяналт, шалгалт хийх, захиргааны акт гаргах, хариуцлага хүлээлгэх.эдгээрийг бэлтгэх.хэлэлцэх, оролцох,ажлын хэсэг ахлах, тендерийн болон үнэлгээний хороонд ажиллахын өмнө ашиг сонирхлын зөрчил үүссэн, эсхүл үүсэхээр бол албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдлийг харъяалах нэгжийн даргадаа тухай бүр гаргаж, эрх бүхий албан тушаалтанд бүртгүүлж байх;

6.3.10 Албан тушаал, өөрийн өмчийн байдал, тэдгээрт орсон өөрчлөлт, орлогын талаар эрх бүхий байгууллагад үнэн зөв мэдээлэх;

6.3.11 Ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүрэг, үр дүнгийн гэрээгээр тохиролцсон бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний хэрэгжилтийг биечлэн хангах;

6.3.12 Хийсэн хяналт шалгалт, гаргасан дүгнэлт, бичсэн акт, албан шаардлага, тоо, баримтын үндэслэл, нотолгооны үнэн зөвийг бүрэн хариуцах;

6.3.13 Улсын байцаагч, дотоод аудитор нь үнэмлэх, тэмдгээ дур мэдэн бусдад шилжүүлэх, ашиглуулах, барьцаалах, хадгалуулах, үрэгдүүлэх, гэмтээх, хууль бусаар хийлгэх, хэлбэр загварыг өөрчлөх, хувилах, албаны бус ажилд ашиглахыг хориглох;

6.3.14 Гарын үсэг зурж баталгаажуулсан акт, дүгнэлт, албан шаардлага, бусад баримт бичгийг засварлах, өөрчлөхийг хориглох;

6.3.15 Шалгуулагч этгээдээс хууль тогтоомжид заагаагүй баримт бичиг, мэдээлэл шаардахыг хориглох;

6.3.16 Хийсэн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэдээ, мэдээлэл, судалгаа, тайлан, биелэлт, боловсруулсан баримт бичиг, гаргасан шийдвэрийнхээ эцсийн хариуцлагыг хүлээх;

6.3.17 Бусад албан хаагчийн үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх, саад болох, хууль бус үйлдэл хийхийг шаардах, үүрэг даалгавар өгөхийг хориглох

6.4. Төрийн захиргааны албан хаагч нь энэхүү дүрмийн 5.1.3-т заасан эрхэмлэн

дээдлэх зүйлсийн хүрээнд дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

6.4.1. Холбогдох хууль, журам, заавар, хяналтын хуудсыг сурталчлан таниулах, тэдгээртэй танилцах, татаж авах арга замыг зааж өгөх зэргээр хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн актын ил тод, нээлттэй байдлыг хангах;

6.4.2. Холбогдох асуудлаар сэрэмжлүүлэг, анхааруулга, зөвлөгөө, зөвлөмж бэлтгэж, нийтийн хүртээл болгох;

6.4.3. Харьяалах удирдлагын зөвшөөрлөөр эсхүл зохих шатны хуралдаанаар хэлэлцэгдсэн, нууцын зэрэглэлтэйгээс бусад хяналт шалгалтын ажлын дүнг нийтэд мэдээлэх;

6.4.4. Хяналт шалгалтыг зөвхөн эрх зүйн үндэслэл, журмын дагуу удирдамжийн хүрээнд хяналтын хуудас хэрэглэн явуулах;

6.4.5. Хяналт шалгалтыг аливаа хөндлөнгийн нөлөөнд үл автан бүрэн гүйцэт хийх, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

6.4.6. Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэд, үйлчлүүлэгч, хамтран ажиллагсадтайгаа эелдэг, адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцаж, төрийн үйлчилгээг чирэгдэл, ялгаварлалгүйгээр шуурхай хүргэх;

6.4.7. Иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэх, иргэн, хуулийн этгээдийн хуулиар тогтоосон нууцыг хуульд зааснаас бусад тохиолдолд задруулахгүй байх;

6.4.8. Төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн хандлагаар нь ялгаварлан гадуурхахгүй байх;

6.4.9. Танил тал, найз нөхөд, гэр бүл, төрөл садангийн хүмүүс ажиллаж байгаа байгууллага, тэдний ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шийдвэр гаргах, албаны нэр барих зэргээр албан тушаал, эрх мэдлээ хууль бусаар ашиглахыг цээрлэх;

6.4.10. Шалгуулагч этгээдтэй үгсэн хуйвалдах, ая тал засах, зөрчил, түүний шалтгаан нөхцөл, нотлох баримтыг нуун дарагдуулах, дутагдлыг хаацайлахыг хориглох;

6.4.11. Нотлох баримтаар тогтоогдоогүй байхад ашиг хонжоо олох, хувийн өс хонзон авах зорилгоор шалгуулагч этгээдийг буруутгах, дарамт шахалт үзүүлэх, бусдад давуу байдал олгох, бодит байдалд нийцэхгүй дүгнэлт гаргах зэргээр албан тушаалаа урвуулан ашиглахыг хориглох.

6.5. Төрийн захиргааны албан хаагч нь энэхүү дүрмийн 5.1.5-д заасан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээнд дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

6.5.1. Албан үүргээ хэрэгжүүлэхдээ хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны

ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэх;

6.5.2. Төрийн албаны соёл, дэг журмыг баримтлан иргэдтэй төлөв төвшин харилцах;

6.5.3. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг зохих дүрэм, журмын дагуу цаг алдалгүй, ил тод, түргэн шуурхай хүргэх;

6.5.4. Ажил гүйцэтгэх мэдлэг, чадвар, сахилга хариуцлага, зан байдлаараа иргэд, олон нийтийн итгэл, хүндэтгэлийг хүлээж ажиллах;

6.5.5. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдол, хүсэлт, албан бичгийг хуулийн хугацаанд шуурхай, бүрэн шийдвэрлэж байх.

Долоо. Улсын байцаагч, дотоод аудиторын ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх

7.1. Улсын байцаагч, дотоод аудиторын ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд байгууллагын дарга хяналт тавьж ажиллана.

7.2. Улсын байцаагч, дотоод аудиторын ёс зүйн зөрчлийг Төрийн албаны салбар зөвлөлөөр хянан шийдвэрлүүлнэ.

7.3. Улсын байцаагч, дотоод аудиторын ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам"-ын дагуу явуулна.

Найм. Ёс зүйн зөрчил гаргагчид хүлээлгэх хариуцлага

8.1. Холбогдох хууль, энэ дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн улсын байцаагч, дотоод аудиторын үйлдэл, эс үйлдэл нь түүнд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

8.2. Сахилгын шийтгэлийг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу даргын тушаалаар оногдуулна. Улсын байцаагч, дотоод аудиторуудад сахилгын шийтгэл оногдуулахдаа энэ дүрмээр тогтоосон ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг урьдчилсан тогтоосон байна.

8.3. Сахилгын шийтгэл ногдуулсан тухай тушаалыг тухайн улсын байцаагч, дотоод аудиторын хувийн хэрэгт хавсаргах бөгөөд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу олон нийтэд мэдээлнэ.